

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Европын төлөө залбирцгаа

Нэг жил хагасын өмнө байгуулагдсан TWR Women of Hope Беларусь үйлчлэлийн зорилго нь сайн мэдээг хуваалцах болон эдгэрэл авчрах онлайн сүлжээг бий болгох явдал юм. Эхний дугаарууд нь тоорхойгүй байдал болон эмх замбараагүй байсан ч мэргэжлийн сургалтын үр дүнд хөтөлбөрүүд нь амьдралын хүнд хэцүү асуудлуудыг хөндөн ярилцахын зэрэгцээ сайн мэдээ болон Эзэний сайн сайхныг мессеж бүрдээ шингээдэг болсон байна.

Үзэгчдийн тоо харьцангуй цөөн хэдий ч YouTube-ийн үзэлтүүд өсөж, Telegram сувгаар дамжуулан сүнслэг үнзгий яриа өрнөж байгаад бид Бурханд талархаж байна. Эдгээр хөтөлбөрийг сонсож, Эзэнээс найдвар эрэн тэмүүлж буй Беларусь эмэгтэйчүүд Эзэний өгсөн найдвараар арвин үр жимс ургуулахын төлөө залбирцгаа.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Бурхан Ааваа, Польш дахь олон эмэгтэйчүүд хүүхэдтэй болж чадалгүй зовж байна. Тэднийг ерөөж, эдгээж, хүүхэд хэмээх үнэт бэлгийг өгч ерөөгөөч. (Эхлэл 21:1)
2. Эзэн минь, өөрийн үнэ цэнэ, өөртөө итгэх итгэлээ карьераар дамжуулан өсгөхийг эрэлхийлж буй Польш эмэгтэйчүүд Таны нүдэнд ямар үнэ цэнэтэй болохоо ойлгох болтугай. (1 Иохан 3:1)
3. Бурхан минь, Португалын залуу эмэгтэйчүүдэд өөрсдийн үнэн төрхийг Танаас олоход нь туслаач. Тэд дарамт шахалтад бууж өгөлгүй, зорилго, зориг, хайр ба үнэнийг Танаас олох болтугай. (Сургаалт үгс 16:4а)
4. Бурхан минь, Португалд болсон шуурганы улмаас

бүхнээ алдсан гэр бүлүүд болон бизнесүүдэд амар тайван, хангалтыг өгөөч. Дахин эхлэх хүч тэдэнд өгөөч. (Исаиа 41:10)

5. Эзэн минь, нийгэм нь хуваагдал, үймээн самуунтай байгаа Румын дахь итгэгчдийг эв нэгдэл, амар тайвны хүмүүс байхад туслаач. (Филиппой 2:14–16)

6. Эзэн минь, Румыны улс төрийн удирдагчдад энэ улсад хэрэгтэй шинэчлэлийг хэрэгжүүлэх мэргэн ухаан, стратеги, шийдэмгий байдлыг өгөөч. (Сургаалт үгс 21:1)

7. Бурхан минь, Оросын эмэгтэйчүүдэд Таны Үгийг хүсэмжлэн эрэлхийлэх үгийн цангааг өгөөч. Итгэгчдийг ч мөн Таны Үгийг тэдэнтэй хуваалцах хүсэлтэй болгооч. (Матай 5:6)

8. Эзэн минь, Орос болон мөргөлдөөн үргэлжилж буй бүх оронд хайртай хүмүүсээ алдсан хүмүүст тайвшрал өгөөч. (Дуулал 147:3)

9. Аав аа, Сербийн багийг бүх насны эмэгтэйчүүдэд, ялангуяа залуу үед хүрэхийн тулд дижитал платформыг үр дүнтэй ашиглахад нь удирдаач. (Дуулал 145:4)

10. Сербийн багийн хуваалцаж буй бүх мессеж, хөтөлбөрүүд найдвар, амар тайван, сүнслэг өсөлтийг авчрах болтугай. Тэдний гадуурхагдсан эмэгтэйчүүд, хүүхдүүдтэй хийж буй ажил Бурханы хайрыг тусгах болтугай. (Лук 4:18)

11. Испанид олон эмэгтэй, хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өдөр бүр өртөж байна. Эзэн минь, тэднийг аврал, эдгэрэл, чөлөөлөлтийн төлөө Өөр лүүгээ дуудаач. (Дуулал 9:9–10)

12. Эзэн минь, Испанийн багт өөрсдийн нийгэм дэх эмэгтэйчүүдэд үйлчилж, хэрэгцээг нь хангахад бүтээлч санаануудыг өгч, удирдаач. (2 Тимот 4:2)

13. Швейцар дахь ээжүүд хүүхдээ гэртээ өсгөн хүмүүжүүлэхдээ баяр баясгалан олж, хүсэмжлэх сэтгэлтэй болоход нь туслаач. (Дуулал 127:3)

14. Бурхан Аав аа, Швейцарийн итгэгчдэд шашин шүтэх эрх чөлөөгөө зоригтой хэрэгжүүлэх хүч өгөөч. Тэд Есүс болон сайн мэдээг амьдралынхаа бүх хэсэгт хэрэгжүүлэх болтугай. (Иошуа 1:9)

15. Эзэн минь, Албанийн удирдагчдад Эзэнээс эмээх эмээлтийг өгөөч. Тэд зөвхөн Таны төлөө ажлаа хийж, Таны үнэн ба зөвт байдал тэдний шийдвэр бүрийг удирдах болтугай. (Сургаалт үгс 9:10)

16. Эзэн минь, Албанийн удирдагчид ядуу дорой, гадуурхагдсан болон өөрсдийн төлөө дуугарч чаддаггүй хүмүүст ашиг тустай хууль тогтоомж гаргах болтугай. (Сургаалт үгс 31:8)

17. Бурхан Аав аа, Беларусийн залуусыг Өөр лүүгээ дуудаач. Тэдэнд гэмшлийн зүрхийг өгөөч. Тэд архинд бус, харин Есүс доторх амийн бэлгийг сонгох болтугай. (Сургаалт үгс 28:13)

18. Бельгийн эмэгтэйчүүдэд зориулсан “Arise and Shine” подкастын 200 дугаар бэлэн болсон явдалд Бурханыг магтъя. Энэ нь Бельги болон Нидерландын эмэгтэйчүүдэд ерөөл болох болтугай. (Дуулал 34:8)

19. Бурхан Аав минь, Украин болон дайны байдалтай бүх орны TWR Women of Hope-ийн ажилтнууд болон тэдний гэр бүлүүдийн бие махбодын болон сүнслэг аюулгүй байдлын төлөө бид залбирч байна. (Дуулал 46:1)

20. Аав аа, Украин болон дайнд нэрвэгдсэн бусад орны TWR болон Women of Hope-ийн ажилтан бүрийг Таны Сүнсээр тосолж, сонсогчдоодоо тайвшрал, урам зориг авчрахад нь хэрэглээч. (2 Коринт 1:3-4)

21. Хорват дахь эмэгтэйчүүдийн амийг хамгаалаач, Эзэн минь. Одоогийн эсвэл хуучин хамтрагчдын заналхийлэл, хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн аминд хүрэх аюулын дохио болж байна. Энэ утгагүй аллагуудыг зогсоогооч. (Дуулал 121:7)

22. Бурхан минь, Хорвагын эмэгтэйчүүдийг удирдах албан тушаалд дэвших, илүү өндөр цалин авах, тогтвортой ажлын байртай болох боломжуудаар ерөөгөөч. (Филиппой 1:6)

23. Дани дахь жирэмсэн эмэгтэйчүүдэд төрөөгүй хүүхдийнх нь төлөө найдвар дүүрэн ирээдүйн тухай Таны бодлыг харуулаач. Тэдэнд халамжилдаг хүмүүсээр дамжуулан тусламж илгээгээч. (Дуулал 139:13,16)

24. Хүүхдээ алдсан Дани эмэгтэйчүүд сэргээн босголт ба найдварын төлөө Танд ирэх болтугай, Есүс ээ. (Иеремиа 30:17)

25. Финландын эмэгтэйчүүдийн гуравны нэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан ч хамгаалалтын захирамжаар хамгаалалт авах боломжтой байдагт Бурханыг магтъя. (Дуулал 25:15-16)

26. Эзэн минь, Францын эмэгтэйчүүд хүндлэгдэх болтугай. Сорилтын үед хүч чадал, нөхцөл бүрд нэр төр, ирээдүйгээ итгэлтэйгээр харах найдвар тэдэнд өгөөч. (Дуулал 46:11)

27. Эзэн минь, Франц дахь ядарсан эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлж, ганцаардсан хүмүүсийг зоригжуулан, Өөрийн нигүүлсэнгүй оршихуйгаар түшиж тэтгээч. (Сургаалт үгс 31:25)

28. Аав аа, Герман дахь ганц бие ээжүүд Таны ойр байдал, халамжийг мэдрэх болтугай. Тэднийг найдвараар хүчирхэгжүүлж, дэмжлэгээр хүрээлэн, хэрэгцээг нь хангаач. (Дэд хууль 31:6)

29. Энэ намар Нидерландын баг өсвөр насны охидод зориулсан “Girls Talk” шинэ подкастыг эхлүүлэх гэж байна. Аав аа, энэ нь олон мянган охидод хүрч, тэднийг ерөөж, Танд улам ойртуулах болтугай. (Еврей 10:22)

30. Бурхан Аав аа, Норвегийн эмэгтэйчүүд дарамт, ганцаардал, сэтгэлийн тэмцэлтэй нүүр тулах үедээ Таны оршихуйг мэдэрч, дотоод шарх, гэмтлээсээ эдгэрэл ба найдвар олох болтугай. (Матай 11:28)

31. Бурхан минь, “From Wounds to Strength” шинэ подкаст цуврал Норвегийн олон эмэгтэйд найдвар, эдгэрэл, авралын мэдээг хүргэж, сэргэлтийг авчрах болтугай. (Ром 15:13).

Монгол улсын төлөөх залбиралын сэдэв-----

1. Бурхан минь, Өрх толгойлсон 80 гаруй мянган эхчүүдэд хүч чадал өгөөч. Хүүхдээ өсгөх, гэр орноо авч явах хүнд ачааг нь хөнгөлж, Та тэдний хань, хамгаал агч нь байж өгөөч. (Дуулал 68:5)

2. Аав аа, Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийг хамгаалаач. Нуугдмал айдас бүрийг зайлуулж, тэдэнд аюулгүй хоргодох газар, эдгэрлийг хайрлаач. (Дуулал 91:1-2)

3. Эзэн минь, Хөдөө орон нутагт, малын бэлчээрт хүнд хүчир хөдөлмөр эрхэлж буй малчин эмэгтэйчүүдэд эрүүл мэнд, тэвчээр хайрлаач. Тэдний нөр их хөдөлмөрийг ивээж өгөөч. (Сургаалт үгс 31:17)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.